



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Металл хийц, тоног төхөөрөмж, машин
үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх хөтөлбөр”
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн 4.2.3.2, 4.2.4, 5.1.1, 5.1.2, Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ;

1. “Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн яамны төсөвт тусгах, зээл, тусламж, төсөлд хамруулах, бусад хөрөнгийн эх үүсвэрийг ашиглаж хэрэгжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүү-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3 жилийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, 2016 оны эхний улиралд багтаан “Аж үйлдвэрийн бодлогын зөвлөл”-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Нэмэхбаяр-т үүрэг болгосугай.

САЙД



Д.ЭРДЭНЭБАТ



Аж үйлдвэрийн сайдын 2016 оны
01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар
тушаалын хавсралт

МЕТАЛЛ ХИЙЦ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫГ СЭРГЭЭН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд “Монгол улсын ойрын 15-25 жилийн хөгжлийн гол стратеги нь нийгмийн баримжаатай, байгаль орчинд зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай үйлдвэржсэн орон болох явдал мөн” гэж;

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5.2.1.2 дахь заалтад ... “хар төмөрлөгийн үйлдвэрт цувимал боловсруулж, түгээмэл зориулалттай хийц хэсэг, мал аж ахуй, газар тариалан, барилга, хөнгөн үйлдвэр, хүнс, эрчим хүчний салбарт өргөн хэрэглэдэг бага оврын машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тэдгээрийн хийц хэсгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх; зэс хайлуулж, холбооны кабел утас, ороомог, машин, тоног төхөөрөмжийн эд анги, хийц үйлдвэрлэж экспортод гаргах” гэж;

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.2.2.1 дэх заалтад “Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ” гэж;

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоол “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн 4.2.3 – д “Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх”, 4.2.4 –г “Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, нийгэм, эдийн засгийн үр ашиг бүхий үндсэн материалын, машин, тоног төхөөрөмжийг угсрах, болон бусад боловсруулах, дахин боловсруулах бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт санхүүгийн бодлогоор дэмжих” зорилтуудыг тус тус дэвшүүлсэн нь “Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Монгол улс сүүлийн 5 жилд нийт 13,6 тэрбум ам.доллар буюу жилд дунджаар 2,7 тэрбум ам.долларын металл хийц, тоног төхөөрөмж, машин механизм импортолсон нь манай улсын нийт импортын 56-60 хувийг эзэлж, хэрэглээний эдийн засгийн бүтцийг бий болгон, эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц томоохон хүчин зүйл болоод байна.

Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үед металл боловсруулалтын салбарын тогтвортой хөгжил алдагдаж, олон үйлдвэрүүд үйл ажиллагаагаа зогсоосон хэдий ч Япон улсын зээлийн хөрөнгөөр Дархан хотод 100 мянган тонн ган үйлдвэрлэх хүчин чадалтай төмөрлөгийн үйлдвэрийг

1994 онд ашиглалтад оруулсан нь Монгол улсад металлургийн үйлдвэрлэлийн салбар сэргэн хөгжих эх суурь тавигдсан.

Уул уурхайн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, катодын цэвэр зэс, тээрмийн ган бөмбөлөг, ган бүтээгдэхүүн, ган туйван зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэл бүхий металл боловсруулах олон үйлдвэрүүд 1990 оноос хойш ашиглалтад орж өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн автомашин, хиймэл дагуул, роботын эд анги, нарны зайн хураагуур үйлдвэрлэн экспортлох болон авто угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа, үе шат, баримтлах зарчим

2.1 Хамрах хүрээ

- 2.1.1 Металл боловсруулах үйлдвэрлэл
- 2.1.2 Металл хийц, тоног төхөөрөмж, машин, механизмын сэлбэг эд ангийн үйлдвэрлэл
- 2.1.3 Машин, механизм угсралтын үйлдвэрлэл

2.2 Хэрэгжүүлэх хугацаа

- 2.2.1 Хөтөлбөрийг 2016-2025 он хүртэл хэрэгжүүлнэ.

2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг дараах хоёр үе шаттайгаар хөгжүүлнэ.

- 2.3.1 Нэгдүгээр үе шат буюу аж үйлдвэрийг хамгаалалтын бодлогоор дэмжих үе (2016-2020)
- 2.3.2 Хоёрдугаар үе шат буюу аж үйлдвэрийн дэмжих бодлого хэрэгжүүлэх үе (2020-2025)

2.4 Баримтлах зарчим

- 2.4.1 Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйлдвэрлэлийг дэмжих тухай багц хуультай нийцсэн байх;
- 2.4.2 Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ээлтэй, олон улсын дэвшилтэт, өндөр технологийг нэвтрүүлэх;
- 2.4.3 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан байх;
- 2.4.4 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн импортыг орлох, экспортыг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих;

- 2.4.5 Бүс нутгийн болон дэлхийн аж үйлдвэрийн салбарын интеграцад нэмүү өртөг шингэсэн үйлчилгээ, бүтээгдэхүүнээр нэгдэх;

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.1 Хөтөлбөрийн зорилго:

Монгол Улсад олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн ам, хүрээлэн буй орчинд ээлтэй, металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2 Хөтөлбөрийн зорилт:

Зорилт 1. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын ханган нийлүүлэгч жижиг, дунд үйлдвэрлэгчдийг өсгөн бойжуулах, кластерт орсон өндөр технологийн аж үйлдвэрлэлийн сүлжээг бий болгох эрх зүй, татвар, бизнесийн таатай орчныг үе шаттайгаар бүрдүүлэх;

Зорилт 2. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх тогтолцоог толгой үйлдвэрүүдийг дагасан технологи, санхүү, хариуцлага, үйл ажиллагааны уялдаа бүхий үйлдвэрүүдийн нэгдлүүд /кластер/-ийг байгуулах замаар бий болгож, үйлдвэр технологийн парк болон чөлөөт бүсүүдэд хөгжүүлэх;

Зорилт 3. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөх стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх түвшинд хүргэх;

Зорилт 4. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчний нөөцийг бий болгох;

Зорилт 5. Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг санхүү, зээл, худалдан авалтын бодлогоор дэмжих;

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын ханган нийлүүлэгч жижиг, дунд үйлдвэрлэгчдийг өсгөн бойжуулах, кластерт орсон өндөр технологийн аж үйлдвэрлэлийн сүлжээг бий болгох эрх зүй, татвар, бизнесийн таатай орчныг үе шаттайгаар бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- 4.1.1 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэл болон бусад хүнд үйлдвэрлэлийн салбарыг тэргүүлэх, хөрөнгө оруулалтыг татах салбар болгон зарлах;
- 4.1.2 Металл хийц, тоног төхөөрөмж, машин механизм үйлдвэрлэлийн салбарт олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх үе шаттай ажлыг төр, хувийн

хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулж, аж ахуй нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгох;

- 4.1.3 Металл бэлдэц, эд ангийг экспортлох, импортлоход Монгол Улсад хэрэглэж буй зарим нэршлийг олон улсад хэрэглэгддэг нэршилтэй адил болгон өөрчлөх ажлыг зохион байгуулах;
- 4.1.4 Дотооддоо үйлдвэрлэх боломжтой металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын ижил, төстэй бүтээгдэхүүний импортын гаалийн татварыг шат дараатайгаар нэмэгдүүлэх;
- 4.1.5 Олон улсын болон Монгол улсын чанар, стандартын шаардлагад нийцсэн, Монгол улсад үйлдвэрлэдэггүй, орлуулах боломжгүй түүхий эд, хагас боловсруулсан материал, үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, санал боловсруулах;
- 4.1.6 Бүрэн задаргаатай иж бүрдэл /CKD/, хагас задаргаатай иж бүрдэл /SKD/ угсрах үйлдвэрлэлийн менежментээр үйлдвэрлэх бараа, бүтээгдэхүүний эд анги, сэлбэгийн иж бүрдлийн багцын кодыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д бий болгож, үйлдвэрлэлд шаардлагатай сэлбэг, эд анги, материалын иж бүрдлийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас үе шаттайгаар чөлөөлөх асуудлыг судалж, санал боловсруулах;
- 4.1.7 Тоон удирдлагатай /CNC/, өндөр технологийн суурь машины гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлөх асуудлыг судалж, санал боловсруулах;
- 4.1.8 Хөтөлбөр хэрэгжих хугацаанд жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх хөтөлбөрийг тусгуулж байх;
- 4.1.9 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк, кластерт орсон үйлдвэрүүдэд шаталсан татварын хөнгөлөлт үзүүлэх хуулийн төсөл боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг УИХ-д хүргүүлэх.
- 4.1.10 Нийслэлийн нийтийн тээвэр, такси болон хот доторх түгээлтийн үйлчилгээний бага оврын ачааны тээврийн хэрэгслийг хийнд шилшүүлэх ажлыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх;

4.2. Метал хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх тогтолцоог толгой үйлдвэрүүдийг дагасан технологи, санхүү, хариуцлага, үйл ажиллагааны үялдаа бүхий үйлдвэрүүдийн нэгдлүүд /кластер/-ийг байгуулах замаар бий болгож, үйлдвэр технологийн парк болон чөлөөт бүсүүдэд хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ;

- 4.2.1 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн үйлдвэр технологийн парк болон чөлөөт бүс байгуулах газар зүйн байршлыг хүний нөөц, дэд бүтэц, зах зээлийг харгалзан тодорхойлох;
- 4.2.2 Дотоодын хэрэгцээг хангах болон бүс нутгийн зах зээл рүү чиглэсэн металл хийц, тоног төхөөрөмж, автомашины эд анги, сэлбэг хэрэгслийн үйлдвэр технологийн паркийг дэд бүтэц, зам харилцааг түшиглэн байгуулж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах;
- 4.2.3 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт тусгай зөвшөөрөл бүхий 2-оос илүүгүй дараах чиглэлийн толгой угсралтын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.
- Уул уурхай, барилгын тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл угсрах, түүний эд анги үйлдвэрлэх үйлдвэр
 - Автобус, цахилгаан машин угсрах, түүний эд ангийг үйлдвэрлэх үйлдвэр
 - 0,5-60 тоннын даацтай ачааны машин угсрах, түүний эд ангийг үйлдвэрлэх үйлдвэр
 - Суудлын автомашин угсрах, түүний эд ангийг үйлдвэрлэх үйлдвэр
 - Хөдөө аж ахуйн машин механизм, чиргүүл угсрах, түүний эд ангийг үйлдвэрлэх үйлдвэр
 - Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйлдвэр
 - Мотоцикл, унадаг дугуй угсрах, түүний эд ангийг үйлдвэрлэх үйлдвэр
- 4.2.4 Технологи, санхүү, хариуцлага, үйл ажиллагааны уялдаа бүхий үйлдвэрүүдийн нэгдлүүд /кластер/-ийг бий болгоно.
- 4.2.5 Үйлдвэр технологийн парк, кластерт орсон аж ахуйн нэгжүүд, чөлөөт бүсэд үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчдэд эрчим хүчийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг бүрдүүлэх;
- 4.2.6 Гадаадын хөрөнгө оруулалт, менежментийн ур чадварыг ашиглах замаар дотоодын компаниудыг дэмжих, экспортын үйлдвэрлэлийн чөлөөт бүс байгуулах;
- 4.2.7 Төр, хувийн хэвшлийн үр өгөөжтэй түншлэлийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах;
- 4.2.8 Монгол-Япон улсын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Япон улсын машин үйлдвэрлэлийн зах зээлд металл хийц, сэлбэг, эд анги нийлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
- 4.2.9 Үйлдвэрлэгчдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэн, үйлдвэрлэгчид хоорондоо мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.2.10 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөрөнгө оруулалт, зээл, санхүүгээр дэмжих;

- 4.2.11 Чанарын шаардлага хангасан зориулалтын хуванцар тоноглол, эд ангийг дотооддоо үйлдвэрлэж буй аж ахуй нэгжүүдийг дэмжих, хамтран ажиллах;

4.3 Метал хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарыг олон улсын зах зээлд өрсөлдөх стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх түвшинд хүргэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 4.3.1 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт олон улсад мөрдөж байгаа эрх зүйн баримт бичигт нийцүүлэн үндэсний техникийн зохицуулалт, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- 4.3.2 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн бүхий л үе шатуудад орчин үеийн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн зарчим, байгаль орчны удирдлагын ISO 14001 стандартыг нэвтрүүлэх;
- 4.3.3 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чанар, стандарт, тохирлын үнэлгээ, дүгнэлт гаргах техникийн экспертийн тогтолцоог бий болгож, төвлөрсөн лабораториудыг байгуулах;
- 4.3.4 Төрийн зүгээс металл хийц, тоног төхөөрөмж машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд борлуулах гарцыг бий болгох;

4.4 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчний нөөцийг бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ;

- 4.4.1 Машин үйлдвэрлэл, металл боловсруулалтын салбарт ажиллаж байгаа инженер, техникийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг дэв олгох сургалт, шалгаруулалтын тогтолцоог бий болгох;
- 4.4.2 Машин үйлдвэрлэлийн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэж буй их, дээд сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийн сургалтын хөтөлбөрт шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт хүүхдийн сэтгэлгээг хөгжүүлэх хөтөлбөрийг нэвтрүүлэх;
- 4.4.3 Техникийн чиглэлийн их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүдэд тоон удирдлагатай (CNC) машин бүхий лабораториуд байгуулах ажлыг зохион байгуулах, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн дадлагын баазыг кластераар хөгжиж байгаа үйлдвэрүүдэд тулгуурлан байгуулах;
- 4.4.4 Техникийн зураг зүй, үйлдвэрлэлийн автоматжуулалтын “/CAD,CAE,CAM/”-ийн хичээлийг инженер бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын үндсэн хөтөлбөрт оруулах;
- 4.4.5 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг тодорхойлж, тэдгээрийг

- үндэсний хэмжээнд болон гадаад улс орнуудад хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шаттай уялдуулан бэлтгэх;
- 4.4.6 Үйлдвэрийн удирдах инженер, техникийн ажилтнуудыг машин үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудын үйлдвэртэй танилцах, дадлагажих, гадаадын их, дээд сургуульд машин үйлдвэрлэлийн салбарын шаардлагатай мэргэжлээр суралцуулах;
- 4.4.7 Машин үйлдвэрлэлийн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийх, өндөр технологийн суурь машин, тоног төхөөрөмжөөр ажил гүйцэтгэх чадвар суулгах, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- 4.4.8 Их дээд сургууль, мэргэжил сургалтын төвүүдийн багшлах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг сайжруулах арга хэмжээг үйлдвэрлэгчид болон мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;
- 4.4.9 Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бүрдүүлэх;
- 4.4.10 Гадаадын зээл тусламж, төсвийн хөрөнгөөр гадаадад суралцаж, дадлагажиж байгаа оюутны 5-аас доошгүй хувийг механик инженер, металл боловсруулах технологи, металл судлал, авто инженер, үйлдвэрийн автоматжуулалтын чиглэлээр сургах;

4.5 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг санхүү, зээл, худалдан авалтын бодлогоор дэмжих;

- 4.5.1 Улсын болон орон нутгийн төсвөөс аймаг, бүсийн хөгжлийг дэмжих чиглэлээр зарцуулж байгаа хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэрийг энэхүү хөтөлбөрийн хэрэгжилттэй нягт уялдуулан төлөвлөж, зарцуулах;
- 4.5.2 Төр захиргааны байгууллагууд болон төрийн өмчит компаниудын металл хийцийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, машин механизмын эрэлт, хэрэгцээг урьдчилан тодорхойлж, урт хугацааны стратегийн худалдан авалтын гэрээг үндэсний үйлдвэрлэгч компаниудтай байгуулах замаар худалдан авалтын бодлогоор дэмжих цогц арга хэмжээ авах;
- 4.5.3 Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад зохих нэмэлт, өөрчлөлтийг оруулах;
- 4.5.4 Дотоодын металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах хөшүүргийн тогтолцоог бий болгож, худалдан авалтыг урамшуулах;
- 4.5.5 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи ашиглан импортыг орлох үйлдвэрлэл эрхлэх, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийг урт хугацаатай зээлийн бодлогоор дэмжих;
- 4.5.6 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад улс орнуудын хөнгөлөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах бусад хөтөлбөр, шийдвэртэй уялдуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үүргийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Аж үйлдвэрийн бодлогын зөвлөл байгуулж хэрэгжүүлнэ.

5.2 Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.3 Хөтөлбөрийг салбарын үйлдвэрлэгчид, орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчид, мэргэжлийн холбоод, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, боловсролын болон шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.4 Аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг жил бүр нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1 Хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 6.1.1 Аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө;
- 6.1.2 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 6.1.3 Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- 6.1.4 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;
- 6.1.5 Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 6.1.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэр;
- 6.1.7 Шинжлэх ухаан, технологийн сангийн эх үүсвэр;
- 6.1.8 Бусад эх үүсвэр;

Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.1 Хөтөлбөр хэрэгжиж дуусахад доорх үр дүнд хүрсэн байна.

- 7.1.1 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбар хөгжих эрх зүйн таатай орчин бүрдсэн байна.
- 7.1.2 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрүүдээс хангах явцыг тасралтгүй өсгөх замаар импортоор авах

энэ төрлийн бүтээгдэхүүний хэмжээг 2015 оны түвшингээс 50 хувь хүртэл бууруулсан байна.

- 7.1.3 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нийт экспортын 10-аас доошгүй хувийг эзэлнэ.
- 7.1.4 Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын үйлдвэр технологийн парк байгуулагдаж, кластер хэлбэрээр хөгжиж, чөлөөт бүс байгуулагдаж 1000-аас доошгүй хүний ажлын байр бий болсон байна.
- 7.1.5 Мэргэжил дээшлүүлэх, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр, тогтолцоо бүрэлдсэн байна.

7.2 Хөтөлбөр хэрэгжсэн үе шат бүрд дараах үр дүнд хүрсэн байна.

7.2.1 *Нэгдүгээр үе шат буюу аж үйлдвэрийн хамгаалалтын бодлогоор дэмжсэнээр 2020 онд хүрэх үр дүн:*

Металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарын дотоодын үйлдвэрүүдийг хөгжүүлэх эрх зүй, бизнес, татварын таатай орчныг бүрдүүлж, орчин үеийн өндөр технологийг нутагшуулна. Импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлнэ. Салбарын үйлдвэр, технологийн парк байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрч, түүхий эдийг дотоодоос хангаж эхэлсэн байна.

7.2.2 *Хоёрдугаар үе шат буюу аж үйлдвэрийг дэмжих бодлого хэрэгжүүлсэнээр 2025 онд хүрэх үр дүн:*

Өндөр технологид суурилсан металл хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбар бэхжиж, экспорт давамгайлсан аж үйлдвэрийн салбар бий болсон байна. Дотоодын нийт хэрэгцээний 20 хувийг дотоодын үйлдвэрүүдээс хангана. Үйлдвэрлэлийн түүхий эдийн 30-аас доошгүй хувийг дотоодын аж ахуйн нэгжүүдээс хангадаг кластер тогтолцоо бүрдүүлнэ.